

# Өөрийн сургуулийн хүний эрхийн температурыг тодорхойлцгооё

## Асуулга

### Танилцуулга:

Оролцогчид нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд үндэслэн боловсруулсан шалгууруудыг ашиглан өөрийн сургууль дахь хүний эрхийн уур амьсгалыг тодорхойлох боломжийг энэхүү асуулга олгож байна. Мөн энэхүү асуулга нь тухайн сургууль, нийгмийн орчин дахь хүний эрхийн цаашдын хэлэлцэх асуудлуудын хүрээг тодорхойлж, улмаар тэдгээрт хандсан үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад чиглэдэг.

### Зорилгууд:

Тухайн сургууль дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх,  
Хүний эрхийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж буй сургуулийн дотоод үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах,  
Сургуулийн дотоод дахь хүний эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх,  
Хамрах хүрээ: Дунд, ахлах ангийн сурагчид, сургуулийн удирдлагууд, эцэг эх, багш нар  
Хугацаа: 1-2 цаг

### “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал”

### Зааварчлага:

- Та бүхэн өөрийн сургуулийн хүний эрхийн температурыг тодорхойлно уу?
- Дараахи мэдэгдлүүдийг анхааралтай уншиж, эдгээр нь танай сургуулийн орчинд хэрхэн тохирч байгааг үнэлж, урьд нь байгаа зайд тэмдэглэнэ үү? (Өөрийн сургуулийн бүхий л гишүүд, тухайлбал, суралцагчид, багш нар, удирдлагын болон үйлчилгээний ажилтнуудыг хамруулан төсөөлнө үү?) Үүний дараа, өөрийн сургуулийн ерөнхий үнэлгээний оноог тодорхойлно уу?

### Эрэмбэлэх хэмж

- 1 – Үгүй/ Хэзээч үгүй
- 2 – Маш ховор
- 3 - Ихэвчлэн
- 4 – Тийм/ Байнга

Асуулга:

- \_\_\_ 1. Манай сургууль бол оюутан, сурагчдын хувьд аюулгүй бөгөөд бүрэн хамгаалагдсан орчин мөн. (Зүйл. 3. 5)
- \_\_\_ 2. Бүхий л оюутан суралцагчид суралцах болон дэвшин хөгжих бололцоо, түүнтэй холбоотой мэдээлэл, урамшууллыг адил тэгшээр хүртдэг. (Зүйл. 2)
- \_\_\_ 3. Сургуулийн хамт олон, түүний гишүүд нь тэдгээрийн хувцаслалтын хэв маяг, хэн нэгэн хүнтэй хамтран үйлдэж байгаа болон сургуулиас гадуур явуулж буй үйл ажиллагаа зэрэг амьдралын хэв маягаас шалтгаалан ямарваа ялгаварлан гадуурхалд өртдөггүй. (Зүйл. 2. 16)
- \_\_\_ 4. Манай сургууль нь өөрийн бүхий л гишүүддээ хуваарь ёсоор анги танхим, хичээлийн хэрэглэгдэхүүн, үйл ажиллагаа, үнэлгээнд адил тэгш байх нөхцлийг хангадаг. (Зүйл. 2. 7)
- \_\_\_ 5. Манай сургуулийн хамт олон, түүний гишүүд нь сургууль дээрээ хүний нэр төрийг гутаасан болон ялгаварлан гадуурхсан ямар нэгэн үйлдэл ба эд зүйлсийг эсэргүүцэх болно. (Зүйл. 2, 3, 7, 28, 29)
- \_\_\_ 6. Хэн нэгэн хүн бусдын эрхийг зөрчих буюу нэр төрд нь халдвал тийнхүү үйлдэгч нь өөрийн үйл байдлыг хэрхэн өөрчлөх талаар бусдаас туслалцаа авдаг. (Зүйл. 26)
- \_\_\_ 7. Манай сургуулийн хамт олон нь шаардлагатай үед миний сургалтын үйл ажиллагаанд анхаарал тавьж, надад туслaxyг хичээдэг. (Зүйл. 3, 22, 26 ба 29)
- \_\_\_ 8. Хэрвээ ямар нэгэн зөрчил үүсвэл бид түүнийг хүчирхийллийн бус, зөвшилцлийн арга замаар шийдвэрлэхийг хичээдэг. (Зүйл. 3, 28)
- \_\_\_ 9. Ялгаварлан гадуурхах аливаа халдлагатай холбоотой гомдол гарсан бол тухайн байгууллагын дүрэм журам, бодлогууд нь түүнийг шийдвэрлэхэд чиглэдэг. (Зүйл. 3, 7)
- \_\_\_ 10. Дэг журамтай холбоотой асуудал (хасах, хөөх зэрэг) гарсан тохиолдолд ял шийтгэл, гэм бурууг тодорхойлоход бүх хүнд алагчлалгүй хандаж, шударгаар шийдвэрлэдэг. (Зүйл. 6, 7, 8, 9 10)
- \_\_\_ 11. Манай сургуульд доромжлон хандах, ял шийтгэлд өртсөн хэн ч байхгүй. (Зүйл. 5)
- \_\_\_ 12. Хэн нэгэн хүн гэм бурууд холбогдвол түүний бурууг нотлох хүртэл гэмгүйд тооцох болно. (Зүйл. 11 )
- \_\_\_ 13. Миний хувийн орон зай ба юмс бусдаар хүлээн зөвшөөрөгдөж хүндлэгддэг. (Зүйл. 12. 17)
- \_\_\_ 14. Манай сургуулийн хамт олон зөвхөн Монголд төрсөн гэлтгүй янз бүрийн угсаа гарал, соёл бүхий оюутан, багш, ажилтнуудыг хүлээн авахдаа таатай байдаг. (Зүйл.2, 6,13, 14,

15. Миний бие аливаа ялгаварлан гадуурхах үзлээс айж эмээлгүйгээр өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлоо (улс төрийн, шашны болон соёлын) илэрхийлэх эрх чөлөөтэй. (Зүйл. 19)
16. Манай сургуулийн хамт олон, түүний гишүүд нь аливаа хяналт болон ял шийтгэлгүйгээр бүтээлээ хэвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөөтэй. (Зүйл. 19)
17. Үзэл санаа, итгэл үнэмшлийн ялгаанууд нь (хүйсийн, үндэсний, үзэл суртлын) хичээл, сурах бичиг, номын сан болон сургалтын хөтөлбөрт тусгагдсан байдаг. (Зүйл. 2, 9, 27)
18. Миний хувьд хөгжим, урлаг, бичгийн хэлбэрээр дамжуулан өөрийн соёл, уламжлалаа илэрхийлэх боломж байдаг. (Зүйл. 19, 27, 28)
19. Манай сургуулийн хамт олон, гишүүд нь өөрийн сургуулийн бодлого, дүрмийг тодорхойлох шийдвэр гаргах үйл явцад (хувиараа болон байгууллагаар дамжуулан) оролцох боломж нээлттэй байдаг. (Зүйл. 20, 21, 23)
20. Манай сургуулийн гишүүд нь өөрсдийн болон бусдын эрхийн төлөө туслах зорилго бүхий байгууллага, эвсэл холбоо байгуулах эрхтэй. (Зүйл. 19, 20, & 23)
21. Манай сургуулийн хамт олон зүй ёсны нийгэм, экологи, ядуурал, энх тайван зэрэг нийгмийн болон дэлхий нийтийн асуудлуудыг танин мэдэх, ойлгон ухаарахад харилцан бие биендээ туслаж дэмждэг. (Оршил, Зүйл. 26. 29)
22. Манай сургуулийн хамт олон зүй ёс, экологи, ядуурал, энх тайван зэрэг нийгмийн болон дэлхий нийтийн асуудлуудтай холбогдсон үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулахад харилцан бие биенээ дэмжиж тусладаг. (Оршил, Зүйл. 20. 29)
23. Манай сургуулийн хамт олон зохистой хөдөлмөрийн нөхцөлд, ажлын өдрийн турш тохиромжтой цагаар ажиллаж, амрах, завсарлах боломжтой. (Зүйл. 23. 24)
24. Манай сургуульд ажиллагсад нь өөрсдөө болон гэр бүлийн хамт эрүүл мэндийн болон сайн сайхны зохистой түвшинд (орон байр, хоол хүнс, ажилгүйдэл, өвчин эмгэг болон хөгшрөлттэй холбогдох нийгмийн хамгаалал зэргийг оролцуулан) амьдрахуйц цалин хөлс авдаг. (Зүйл. 22. 25)
25. Хүн бүрд сургуулийн хамт олны аюулгүй, сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн, бусдыг үл ялгаварлан гадуурхсан байдлаар биеэ авч явах үүрэг хариуцлага оногддог. (Зүйл. 1. 29)

Хамгийн зохистой температур = 100 Хүний эрхийн хэм

Манай сургуулийн температур: \_\_\_\_\_

### **Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах:**

Оролцогчид нь өөрсдийн сургуулийн хүний эрхийн “температур”-т үндэслэн “Сургуулийн орчинд хүний эрхийг хангах Үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах даалгаврыг гүйцэтгэнэ.

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахын тулд асуулгаар бий болсон судалгааны дүнг хэлэлцэж, дараах асуултуудын дагуу анализ хийнэ үү. Танай сургуульд хүний эрхийн ямар зарчмуудыг баримталж, даган мөрддөг вэ?

Ямар асуудлуудыг хүний эрхийн асуудлууд гэж тооцдог вэ?

Тэдгээрийн аль нь таны анхаарлыг илүү татдаг вэ?

Хүний эрхийн зөрчлийн гол шинжүүдийг тодорхойлж, жишээ гаргаж, асуудлыг тодруулна уу?

Яагаад хүний эрхийг зөрчих нөхцөл байдал бий болсон бэ?

\* Одоо оршин буй хүний эрхийн зөрчлүүд нь хэнд ашигтай ба хэнд хохиролтой вэ?

\* Анхаарал татахуйц өөр асуудлууд байна уу

е. Танай сургуулийн хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулахыг тулд юу хийх шаардлагатай вэ?

Та болон таны хамт олон хүний эрхийн үнэт зүйлсийг эрхэмлэсэн илүү хүмүүнлиг орчныг бүрдүүлэхийн тулд юу хийж чадах вэ?

4. Тэгээд хүний эрхийн нөхцлийг дээшлүүлэхийн тулд хийж болох ажлын тухай анги бүлгээрээ “Оюуны довтолгоо”-ны арга хэрэглэж, хийж болохуйц ажлын хувилбаруудыг жагсаана. Маргаан мэтгэлцээнээр дамжуулан дээрх жагсаалтуудаас хийж болох үйл ажиллагааны тухай хэлэлцэнэ.

5. Бүлгийн хэлэлцүүлэгт тулгуурлан хийх үйл ажиллагааг сонгож, хөтөлбөр боловсруулан түүний зорилго, стратеги, үүрэг хариуцлагыг тодорхойлно.